

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2018 оныг “**АУДИТЫН ЧАНАР, ҮР ӨГӨӨЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ**” жил болгон зарласантай холбогдуулан тус газраас ажилтнуудад аудитын ажлын чанар, аудитын үр өгөөжийг сайжруулахад онцгой анхаарч аудитын үе шатны ажилд байнгын хяналт тавин, удирдлагын зөвлөлөөр ярилцан хэлэлцэж санал бодлоо солилцох ажлыг тогтмолжуулан, холбогдох хууль, заавар, дүрэм журмыг сайтар судлуулан ажилласны зэрэгцээ аудитад хамрагдсан байгууллагын удирдлагад аудитын тайланг гардуулан өгч, илэрсэн алдаа зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар танилцуулах ажлыг зохион байгуулж хэвшлээ.


ЗОРИЛТ: Байгууллагын хэмжээнд “**АЖИЛЛАГСДЫН АЖЛЫН ТОХЬ ТУХТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЬЕ**” зорилт дэвшүүлж, Үндэсний Аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн, биелэлтийг ханган ажиллав.

Энэ зорилтын хүрээнд ажиллагсдын ажлын байрны нөхцлийг сайжруулах, эко орчинг бий болгох зорилгоор аудитын менежер, санхүүгийн аудитын, нийцлийн болон гүйцэтгэлийн багийн өрөө, дотоод ажилтны өрөө зэрэг албан тасалгаануудад дотор засал, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн, ажлын ширээ, сандал, шүүгээг шинэчлэн 6 албан хаагчдад зөөврийн компьютер, дагалдах хэрэгслийг шинээр хүлээлгэн өгч, өрөө тасалгааг цэцэгжүүлэн, ажилтан бүр 15 цэцэг тарьж ургуулан өрөөний тохь тухтай цэвэр цэмцгэр байдлыг бий болгоход анхаарч ажиллалаа. Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 онд Төрийн аудитын тухай хууль мөн бусад хууль тогтоомжийг удирдлага болгон хүний нөөц болон батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

Аймаг дахь Төрийн аудитын газар бүтэц орон тооны хувьд дарга, тэргүүлэх аудитор, аудитын хэлтэс буюу аудитын менежер, ахлах аудитор 3, аудитор 5, нийтлэг үйлчилгээний алба буюу нягтлан бодогч, мэдээлэл технологи, дотоод ажил хариуцсан ажилтан/гэрээт/ 1, нярав жолооч 1 гэсэн нийт 12 орон тоотой, 241.4 сая төгрөгийн төсөвтэйгээр нийт 24192 хүн/цаг ажилласан байна.

МУЕА-ын 2017 оны А/69 дүгээр тушаалаар баталсан бүтэц орон тооны дагуу санхүүгийн аудитын албанд 5, гүйцэтгэлийн аудитын албанд 2, нийцлийн аудитын албанд 1 хүний бүрэлдэхүүнтэй 3 багийн зохион байгуулалтаар нийт 12 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Нягтлан бодогч, дотоод ажил, мэдээлэл технологи хариуцсан ажилтан, нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторор батлуулан ажиллалаа. Санхүүгийн аудитын алба нь ахлах аудитор Б.Наранцэцэг, аудитор Ж.Болор-Эрдэнэ, Ц.Хатанболд, Х.Еркегүл, Ц.Нарангэрэл гэсэн бүрэлдэхүүнтэй, гүйцэтгэлийн аудитын алба нь ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, аудитор Ц.Энхтүвшин, нийцлийн аудитын алба нь ахлах аудитор Н.Туяа, нийтлэг үйлчилгээний албанд нягтлан бодогч, мэдээлэл технологи, дотоод ажил хариуцсан ажилтан Ч.Алтанзаяа, нярав жолооч Т.Отгонбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын байгууллагын бүтэц орон тоо



Энэ жилийн хувьд аймгийн ИТХ-ын байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг эрчимжүүлж, хийгдсэн аудитын тайлан бүрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, хурлын байгууллага нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой тогтоол, шийдвэрийг гарган холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Үүнд: Эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулах, бүтэц харъяаллыг нь шийдвэрлэх тухай, Архигүй Хэнтий хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх тухай, орон нутгийн өмчийн болон газрын дуудлага худалдааны үйл ажиллагааг сайжруулах, аймагт хэрэгжиж буй малжуулах төсөл хөтөлбөрийн үр дүнг тооцож байх талаар тодорхой шийдвэрүүдийг гарган ажилласан болно.

МУЕА-ын 2017 оны А/228 дугаар тушаалаар төрийн аудитын байгууллагын дэргэд “Аудитын иргэний танхим”-ыг байгуулж, иргэдийн бүлгийн үйл ажиллагааны дүрмийг баталж, Хэнтий аймагт туршилтын журмаар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд Аудитын иргэний танхимын өрөөг бий болгон 5.2 сая төгрөгөөр засварлан тохижуулж, 5.3 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч нийт 10.5 сая төгрөгийг зарцуулан ажиллах нөхцлийг хангалаа.

Аудитын “Иргэний танхим”-ын нээлтийг 2018 оны 3 дугаар сард зохион байгуулж, МУЕА Д.Хүрэлбаатар, Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбат, YAГ-ын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал М.Давааням, Нийслэлийн Аудитын газрын тамгын хэлтсийн дарга Г.Цагаанхүү болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Л.Батсайхан, аймгийн ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, аудитын Иргэдийн бүлгийн гишүүн Б.Очирхуяг, Б.Цэрэнчимэд, Т.Эрдэнэбаатар нарын албаны бусад хүмүүс оролцлоо.



Аудитын иргэний танхимын нээлт

Аудитын иргэдийн бүлгийг иргэний нийгмийн байгууллага, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, төсөв санхүү гэсэн иргэдийн төлөөллөөс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж батлуулан гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. Боловсролын салбарын аудитын иргэдийн бүлэг
2. Эрүүл мэндийн салбарын аудитын иргэдийн бүлэг
3. Банк, санхүү эдийн засгийн аудитын иргэдийн бүлэг
4. Уул уурхай дэд бүтэц, байгаль орчны аудитын иргэдийн бүлэг

5. Орон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын аудитын иргэдийн бүлэг.

Иргэдийн бүлгээс 2019 онд хийх аудитын сэдвийн хүрээнд санал авч, хэлэлцэн дарга, тэргүүлэх аудиторт уламжлан 1 сэдвийг 2019 онд төлөвлөгөөнд тусгуулахаар шийдвэрлэсэн. Мөн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитад иргэдийн бүлгээс татан оролцуулж, гүйцэтгэлийн үе шатанд хамтран ажилласан. Цаашид иргэний танхимын үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахад орон тооны хариуцсан ажилтан байх зайлшгүй шаардлага байна.

ХОЁР. АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2018 оны 1 дүгээр сард улс, орон нутгийн төсвийн 58 байгууллагын 90 төсвийн захирагч, нягтлан бодогч, гэрээт аудитын компаниудыг оролцуулан 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын нээлтийг хийлээ.



2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нээлт

Нээлтийн үеэр төсөв захирагч нарт 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүн, Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтаас болон 2017 оны санхүүгийн тайлангийн аудитад баримтлах чиглэл, анхаарах асуудлын талаар танилцуулсан. Мөн нээлтийн үеэр аудитын менежер Б.Наранцэцэг “Санхүүгийн тайлангийн аудитын товч танилцуулга” хийж, санхүүгийн тайлангийн аудитын зорилго, ажлын үе шат гэсэн мэдээлэл хийсэн.



“Санхүүгийн тайлангийн аудитын товч танилцуулга” илтгэл

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас хүсэлт тавьсаны дагуу Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын менежер Г.Гүнжидмаа, ахлах аудитор Ц.Хосбаяр нар хүрэлцэн ирж төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт санхүүгийн тайлан, аудитын талаар тодорхой зөвлөмж, үүрэг чиглэлийг өгч ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн. Түүнчлэн Үндэсний аудитын газрын санхүүгийн газрын ажилтнууд аймгийн Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж, зөвлөмж зөвлөгөө өгч, практик ажиллагаануудыг ажилтнуудад зааварчилж өгсөн нь аудитын чанар үр өгөөжид зохих хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.




Нягтлан бодогч нарын мэргэжил дээшлүүлэх сургалт


Манай байгууллагын гүйцэтгэл, нийцлийн багийн аудиторууд ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын болон Нийцлийн аудитын газарт очиж газар дээр нь заавар зөвлөгөө авч ажилласан нь ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг болсон.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар 6, орон нутгийн ИТХ-ын захиалгаар 3, өөрийн санаачилгаар 3, санхүүгийн тайлангийн аудитаар 295, нийт 307 аудитыг хийсэн байна. Тайлант хугацаанд аудитаар 1836 төрлийн 39993.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 66 төрлийн 1097.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.


Мөн 520 төрлийн зөвлөмж өгснөөс 477 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 91.7 хувь, 64 төрлийн 8507.6 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 19 төрлийн 6991.2 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлэн хэрэгжилт 82.2 хувь, 8 төрлийн 30.9 сая төгрөгийн төлбөрийн актаас 8 төрлийн 30.9 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 100 хувьтай гарсан байна.



Зөвлөмжийн биелэлт



Албан шаардлагын биелэлт



Акт

Аудитаар тавигдсан төлбөрийн актаас 40.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ. 2018 онд хийсэн нийт аудитаар 3936.6 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэж тооцоолон тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлсэн. Энэ нь аймаг дахь аудитын газрын төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 14 төгрөг 77 мөнгөний үр өгөөжийг бий болгожээ. Үр өгөөжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 төгрөг 77 мөнгөөр өссөн байна.

Өмнөх оны төлбөрийн актын 11.2 сая төгрөгийн үлдэгдлээс 9.6 сая төгрөгийг барагдуулж биелэлт 85.7 хувь, 5691,1 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдлээс 5691,1 сая төгрөгийг барагдуулж биелэлт 100 хувь, 83 төрлийн зөвлөмжийн үлдэгдлийн хэрэгжилт 100 хувьтай гарлаа.

2.1. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР



Аймаг дахь Төрийн аудитын газар 2018 онд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 151 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 134 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 10 байгууллагын санхүүгийн тайланд МУЕА-ын тушаалаар итгэл үзүүллээ.

Итгэмжлэлийг сүүлийн 3 жил дараалан зөрчилгүй дүгнэлт авсан, санхүүгийн тайланг НББОУС-ын дагуу алдаагүй, үнэн зөв илэрхийлсэн,

төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажилласан байгууллагуудад Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар гардуулдаг. Дараах байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүй өнжөөн итгэмжлэл гардууллаа. Үүнд: **Аймгийн Онцгой байдлын газар, Татварын хэлтэс, Хилийн цэргийн 287-р анги, Прокурорын газар, Улсын бүртгэлийн газар, аймгийн Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Шүүхийн шинжилгээний алба, Нийгмийн даатгалын сан, Халамжийн сан.**



Онцгой байдлын газар



Татварын хэлтэс




Шүүх




Улсын бүртгэлийн хэлтэс


Дүгнэлт гаргасан 151 санхүүгийн тайлангийн аудитын 109-ыг нь аймаг дахь Төрийн аудитын газар, үлдэх 42-ийг нь хувийн аудитын 2 компаниар гүйцэтгүүлсэн. Санхүүгийн аудитаар өгсөн санал дүгнэлтийн 94.0 хувь буюу 142 нь “зөрчилгүй”, 4.6 хувь буюу 7 нь “хязгаарлалттай”, 1.3 хувь буюу 2 нь “дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт эзэлж байна.



Зөрчилгүй






Хязгаарлалттай



Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Тухайлбал: Мөрөн сумын ЕБС, Цэцэрлэг, Биндэр сумын ЗДТГ, Өлзийт тосгоны ЗАА, Цэцэрлэг, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баянхутаг сумын ТЕЗ –ийн санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт, Баянхутаг сумын ЗДТГ, ЭМТ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтийг өгөв. Тайлант онд хийсэн санхүүгийн аудитаар нийт 12624,8 сая төгрөгийн 662 алдаа, зөрчил илрүүлснээс 1097.7 сая төгрөгийн 66 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 30.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тавигдсанаас биелэлт 100 хувь, 124.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 8 албан шаардлага өгснөөс хэрэгжилт 100 хувь, 465 зөвлөмж өгснөөс 448 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 96.3 хувьтай байна.



Нийт илэрсэн алдаа зөрчлийн дотор хамгийн өндөр хувь буюу 79.9 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил эзэлж байгаа бөгөөд 12.4 хувь нь нягтлан бодох бүртгэл, тайлагналтай, 2.4 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 1.4 хувь дотоод хяналт, хариуцлагатай, 1.0 хувь нь орон нутгийн орлого бүрдүүлэлттэй, 0.5 хувь нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй, 2.4 хувь нь бусад асуудалтай холбоотой зөрчлүүд тус тус эзэлж байна.



Хамгийн өндөр хувийг эзэлж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн 81.6 хувь нь Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон зэрэг зөрчлүүд илэрсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн 5.6 хувь нь арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 31.6 хувь нь бүртгэл тайлагналтай, 53.8 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 6.9 хувь нь дотоод хяналтыг сайжруулах, 2.1 хувь нь бусад асуудалтай холбоотой байна.

Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс гэрээний үндсэн дээр 42 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эич Аудит” ХХК, “Өндөрхаан Итгэл Аудит” ХХК-иуд аудитыг гүйцэтгэж, 140.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын явцад 54.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 138 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, аудит хийлгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан, аудитад шаардлагатай баримт материалыг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, аудит хийхэд саад учруулсан нийт 9 байгууллагын 17 албан тушаалтанд “Төрийн аудитын тухай” хуулийн 28.1, 28.2 дахь заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах болон ажлаас халах албан шаардлагыг хүргүүлжээ. Хүргүүлсэн санал 100 хувь бүрэн хэрэгжсэн байна.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар 579.4 сая төгрөгийн 190 үр өгөөжийг бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Түүнчлэн эрүүл мэнд, боловсролын салбарын төсвийн шууд захирагчдын санхүүгийн аудитын тайланг салбарын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарыг байлцуулан алдаа дутагдлыг зөвлөн тайланг гардуулж өгч эхэлсэн нь шинэлэг ажлын эхлэл байлаа.



Эрүүл мэндийн салбар




Боловсролын салбар



Аймгийн Цагдаагийн газар



Орон нутгийн өмчийн газар



Ус цаг уур, орчны шинжилгээний газар




ГХБХБГазар

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасан цагалбарт хугацаанд аймгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар аймгийн ТЭЗ-ийн харьяа төрийн сан, улс, орон нутгийн төсвийн байгууллага, төсөл сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 133 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 125 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, 1 сангийн санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн болно. Аймаг дахь Төрийн аудитын газар аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайланд хамрагддаг 22 сумын төрийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсний 21 санхүүгийн тайланд “ЗӨРЧИЛГҮЙ”, 1 санхүүгийн тайланд “ХЯЗГААРЛАЛТТАЙ” санал дүгнэлт өгсөн байна.

Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллага, төсөл сан, сумдын төрийн сан, ОНӨҮГ-уудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг шинжтэй 879.2 сая төгрөг, материаллаг бус 6840.7 сая төгрөг, нийт 7719.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 509.6 сая төгрөгийн алдааг холбогдох санхүүгийн тайланд залруулж, 227 зөвлөмж өгч, 70.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 26.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Тогтоосон төлбөрийн актыг 100 хувь барагдуулан, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, хүргүүлсэн албан албан шаардлагын биелэлт 100 хувьтай гарлаа.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД АУДИТЫН ТАЙЛАНГ ГАРДУУЛЛАА.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг аймгийн засаг дарга Н.Ганбямба-д гардууллаа.


Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган, аудит хийгдсэн тайланг ҮАГ-ын САГ, аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн. Аудитыг төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл, төсвийн орлогын гүйцэтгэл, төсвийн зарлагын гүйцэтгэл, төсвийн үр дүн, нэмэлт санхүүжилт гэсэн чиглэлээр хийж гүйцэтгэсэн. Аудитад аймгийн ТЭЗ, орон нутгийн ТТЗ-д, ТШЗ, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулан авч үзлээ. Аудитаар төсвийн орлого болон зарцуулалттай холбоотой нийт 272.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн аудитаар 0.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож,

5.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг дахин давтахгүй байх талаар 87 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар байгууллагын удирдлагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан албан тушаалтнуудад 8.0 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийн талаарх мэдээллийг Захиргааны ерөнхий хуульд заасныг үндэслэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд хүргүүлж ажиллалаа.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн санхүүгийн аудит:

1. **“Төрийн сангийн үйл ажиллагааны тогтолцоо, үр дүн”-д** санхүүгийн аудитыг хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна гэсэн төсвийн тухай хуулийн заалт хэрэгжихгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Аудитыг хугацаанд нь хийж гүйцэтгэн, цахимаар болон цаасаар ҮАГ болон САГ-т хүргүүлсэн. Энэхүү аудитаар нийт 1534.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 7 заалт бүхий зөвлөмж өглөө. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга нарт хүргүүллээ. Зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа болно. Аудитад зарцуулсан хүн/өдөр 96, аудитын өртөг 7.6 сая төгрөг.



2. **“2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д** санхүүгийн аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Орон нутгийн төсвийн орлого нь тооцоо судалгаанд үндэслэгдээгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн. Аудитаар “2017 оны үлдэгдэл орлогоор 2018 оны төсвийг нэмэгдүүлэн батлах тухай” гэж 2018 оны төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг зөрчсөн гэж үзсэн. Мөн аудитаар нийт 451.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нарт 10 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа болно.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 117, аудитын өртөг 4.6 сая төгрөг, аудитын үр өгөөж 9.7 сая төгрөг.

2.2 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Гүйцэтгэлийн аудитын хүрээнд ҮАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 2, өөрийн санаачилгаар 3, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалгаар 2 нийт 7 аудитыг хийж, 1663 байгууллага, иргэдийг хамруулан 1030 төрлийн 8545.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 15 албан шаардлага, 26 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.

Нийт аудитыг 35.0 сая төгрөгийн өртгөөр 531 хүн/өдөр ажиллаж, 258.6 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлээ. Өмнөх оны 4.5 сая төгрөгийн төлбөрийн актыг орон нутгийн төсөвт 100 хувь төвлөрүүлж, 40.0 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт 100 хувь, 37 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хангаж бүрэн хэрэгжүүлсэн.

А.ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудит:

1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжаар гүйцэтгэсэн аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг хийж, аудитын талаар танилцуулга болон холбогдох судалгааг гарган ҮАГ-т хүргүүлсэн. Хэнтий аймагт 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмж шинэчлэх 21350,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээнд 7998,7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 20 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих бол 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэн хэрэгжүүлээгүй байна.

Дээрх төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээ нь нээлттэй, 13 төсөл, арга хэмжээ нь харьцуулалт, 3 төсөл, арга хэмжээ нь шууд гэрээ байгуулсан ба 14 төсөл, арга хэмжээг цахимаар, 4 төсөл, арга хэмжээг цаасаар зохион байгуулсан байна. 2017 оны хөрөнгө оруулалт их засварын ажлын гүйцэтгэлийг 7,4 тэрбум төгрөгөөр баталгаажуулж, санхүүжилтийг 5,9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж он дамжин хэрэгжиж буй 2 төсөл арга хэмжээний 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэл хангалтгүй гэж үзэн санхүүжүүлээгүй байна. Эрүүл мэндийн салбарт батлагдсан 2 төсөл арга хэмжээг үндэслэлгүйгээр хасч, хэрэгжүүлээгүй ба хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр ашиг, үр дүнг тооцоогүй байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 45, аудитын өртөг 2.9 сая төгрөг.



2. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудад хийх аудит”-тай холбоотой судалгаа, фото зургуудыг ҮАГ-т хүргүүлсэн болно.

Аудитад аймгийн ЗДТГ болон 2 сумын ЗДТГ, ОНӨГазар, ГХБХБГ-ыг хамруулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан боловч дуусаагүй 2 барилгын ХАА-ны явц, ажлын гүйцэтгэлийг шалган, хийгдсэн ажлыг газар дээр нь үзэж шалган баталгаажууллаа. Хэнтий аймгийн төв

Өндөрхаан хотод барьж эхэлсэн 8,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хан Хэнтий” чуулгын барилга 7,6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 86%-ийн, Биндэр суманд 5,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажил 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна. “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажлын зураг төсөв, бүрэн баталгаажаагүйгээс дахин хийх, өөрчлөх зэрэг хүндрэлүүд гарсан байна.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 28, аудитын өртөө 1.6 сая төгрөг.

Б.Өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн аудит:

1. “Хэнтий аймгийн газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани болон бусад аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын төлбөрийн ногдуулалт, төсөвт төвлөрүүлсэн байдал”-д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Ус ашиглагчид тавих хяналт сул байгаагаас усны нөөц ашиглах дүгнэлт, гэрээгүйгээр ус ашиглаж, төлбөр ногдуулах ажил хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Аудитад аймгийн ЗДТГазар, Татварын хэлтэс, БОАЖГ, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа, Онон-Улз голын сав газрын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргаа болон ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийг хамруулан ус ашиглах дүгнэлт, гэрээ байгуулах, төлбөр төлсөн байдлыг хамруулан үзлээ.



Аймгийн хэмжээнд аудитад хамрагдсан 64 ААН-ээс 17 аж ахуйн нэгж, иргэн 2017 онд усны нөөц ашиглах дүгнэлт гаргуулснаас 16 аж ахуйн нэгж ус ашиглуулах гэрээ байгуулж усыг тоолуураар тооцсон, үйл ажиллагаагаа хэвийн явуулаагүй 4 ААН-ийн усны төлбөр 304,1 сая төгрөгөөр буурч, 869.4 сая төгрөгийн усны төлбөр төлөхөөс жилийн эцсийн байдлаар 357.9 сая төгрөгийн төлбөр төлөгдөж 5 аж ахуйн нэгж 9.3 сая төгрөгийг илүү, 5 аж ахуйн нэгж 521.8 сая төгрөгийг дутуу төлсөн байна. Мөн дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулаагүй 10 ААН 0,9 сая төгрөгийн ус ашигласны төлбөр төлсөн бол 27 ААН усны нөөц ашигласны төлбөрийг төлөөгүй байгаа нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна. 2017 оны ус ашигласны төлбөрийн үлдэгдэлтэй 5 ААН-ээс 3 нь 518.8 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийг 2018 оны эхний хагас жилд барагдуулснаас аудитын хугацаанд 138.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Аудитаар ус ашиглагч ААН-үүдээс хүсэлтээ гаргасан боловч дүгнэлт нь гараагүй 1, дүгнэлт гаргасан боловч гэрээ байгуулаагүй 2, дүгнэлт, гэрээтэй боловч үйл ажиллагаа явуулаагүй 1, ундны усанд татвар ногдуулсан 1, хүчин төгөлдөр бус маягтаар гэрээ байгуулсан 1 аж ахуйн нэгж зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аймгийн БОАЖГ-т зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд холбогдох байгууллагыг байлцуулан танилцуулж, хуралдаанаар аудитын дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгуулах, ус ашигласны төлбөрийг төсөвт төвлөрүүлж орлого нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох байгууллагад үүрэг болголоо.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 84, аудитын өртөг 5.8 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 138.1 сая төгрөг.

2."Газар болон орон нутгийн өмч хөрөнгийн дуудлагын худалдааны үйл ажиллагаа, үр дүн"-д аудит хийж аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн "Дуудлага худалдааны зарыг олон нийтэд хүртээмжтэй хүргэж, үр дүнг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байх шаардлагатай" гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Гүйцэтгэлийн аудитаар аймгийн ГХБХБГ, ОНӨА-ны болон 18 суманд 2017 онд зохион байгуулагдсан газрын 221, өмч хөрөнгийн 43 дуудлага худалдааны үйл ажиллагаа, орон нутгийн төсөвт оруулсан нийт 492.4 сая төгрөгийн төлбөр хураамжийн баримт материалыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.



Аудитаар 908.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 502.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 8 албан шаардлага, 10 заалт бүхий зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүлэн, аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлээ. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсан.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 67, аудитын өртөг 4.6 сая төгрөг, бүртгэсэн аудитын үр өгөөж 15.1 сая төгрөг.

3."Хэнтий аймгийн боловсролын салбарын төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт"-д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн "СӨБ болон бага дунд боловсролын байгууллагын төсвийг төлөвлөж

хуваарилахдаа санхүүжих дундаж хүүхдийн тоо, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.



Гүйцэтгэлийн аудитад аймгийн сургуулийн өмнөх боловсрол олгох төрийн өмчит 32, хувийн хэвшлийн 2 хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсрол олгох төрийн өмчит 25, хувийн хэвшлийн 1 сургууль, тусгай хэрэгцээт боловсрол олгох 1 төв, нийт 61 сургалтын байгууллагыг хамрууллаа.

Аудитаар 2017, 2018 оны төсвийн төсөл, түүнийг аймгийн БСУГ-ийн хэрхэн хянаж нэгтгэсэн болон Хэнтий аймагт 2017 онд 26,764.5 сая төгрөг, 2018 онд 27,220.7 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг ирснийг сумдад хэрхэн хуваарилсан, гүйцэтгэлд тавих хяналтыг аймгийн БСУГазар хэрхэн хэрэгжүүлснийг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэлээ.

Тус аудитаар боловсролын байгууллагын төсвийг төлөвлөж, хуваарилахдаа санхүүжих дундаж хүүхдийн тоог илүү тооцож, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив баримтлаагүй, төсвийн төслийг боловсруулж, хянахдаа санхүүжих дундаж хүүхдийн тоог статистик мэдээнд суурилалгүй өсгөн тооцсон, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрийг баримтлаагүй, төсвийн зохицуулалт хийхдээ төсвийн шууд болон төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөл авдаггүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Нийт 6364.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 8 заалт бүхий зөвлөмжийг өглөө. Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлсэн. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсан.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 128, аудитын өртөг 8.9 сая төгрөг.

В.Аймгийн Иргэдийн Хурлын захиалгаар гүйцэтгэсэн аудит:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Малжуулах төсөл” хөтөлбөрийн 2014-2017 оны үйл ажиллагаанд аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцох ажил хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.


Аудитаар шаардлага хангаагүй малчныг хөтөлбөрт хамруулсан, ХАА-г ил тод зохион байгуулаагүй, төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй, зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан, хөтөлбөрийн үр дүнг тооцоогүй зэрэг нийт 581,2 сая төгрөгийн 98 алдаа зөрчил илрүүлж 105,4 сая төгрөгийн 4 албан шаардлага,

ХАА-г ил тод зохион байгуулах, малжуулах хөтөлбөрийн зардлыг үр дүнтэй зарцуулах, хөтөлбөрийн үр дүнг тооцох зэрэг 3 заалт бүхий зөвлөмжийг өгч, аудитын тайланг холбогдох байгууллагад хүргүүлэв. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, холбогдох байгууллагад үүрэг даалгавар өгөгдсөн.



Аудитад зарцуулсан хүн/өдөр 55, аудитын өртөг 4.4 сая төгрөг, бүртгэсэн үр өгөөж 105.4 сая төгрөг

2. “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаа”-д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн ажлын хэсэг хангалтгүй ажилласнаас хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй болжээ” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.



Аудитаар шатахуун, ажлын хөлс, томилолт, буудлын зардал, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан тэмцээнд оролцогчдын хувцасны болон тайзны

материал, бусад зүйлд нийт 169.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газарт хөтөлбөрийн төлөвлөгөө, зорилтыг тодорхой болгох, хөтөлбөрийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах зэрэг 2 заалт бүхий зөвлөмжийг өглөө. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан, тэргүүлэгчдийн хуралдаанаас аймгийн Засаг даргад өмнөх зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар анхаарч, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зохион байгуулалтын үр дүнд хүрэхүйц арга хэмжээ авч ажиллахыг даалгасан болно.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 124, аудитын өртөг 6.8 сая төгрөг.


2.3 НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Нийцлийн аудитаар тайлант хугацаанд УАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 2, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалгаар 1 нийт 3 аудит хийж, 234 байгууллагыг хамруулан 115 төрлийн 18823.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 41 албан шаардлага, 29 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж ажиллалаа.

Нийт аудитыг 13.7 сая төгрөгийн өртгөөр 398 хүн/өдөрт хийж, 474.6 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлээ.

А.УАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудит:

1.“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” -д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулахдаа үнэн зөв бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмыг хангах шаардлагатай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.



Аудитаар мэдээлэл байршуулалт өмнөх оноос сайжирсан ч мэдээллийн утга, агуулга, үнэн зөв байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй, 16709.7 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, 43 төрлийн мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн зөрчил илэрч холбогдох албан тушаалтнуудад 5 заалт бүхий зөвлөмжийг өгсөн. Аудитын тайланг бүх төсөв захирагч нарт албан тоотой хүргүүлэв. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-ийн аудитын дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, газар, хэлтэс, боловсрол, эрүүл мэндийн төсвийн шууд захирагч нарт 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулж танилцуулан, цахим хуудасны аль цэсэнд ямар мэдээлэл оруулах талаар зөвлөмж зөвлөгөө өгсөн нь маш үр дүнтэй ажил боллоо гэж үзлээ.



Аудитад зарцуулсан хүн/өдөр 216, аудитын өртөг 2.4 сая төгрөг.

2. “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн” -д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Сангуудын хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийг аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.



Аудитаар СХСангийн зээлийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгах, орлогыг дутуу төлөвлөх, нийт зээлийн үлдэгдлийн 62.4 хувь нь чанаргүй зээлд бүртгэгдсэн, журмын дагуу зээлийг олгоогүй зэрэг 149.7 сая төгрөгийн зөрчил илрэв. ОНХСангийн хөрөнгийг худалдан авах ажиллагааны журам зөрчин зохион байгуулсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн, орон нутгийн иргэдийн саналаар

дэмжигдээгүй ч эрэмбэлэгдсэн жагсаалтад оруулсан, ТЭЗҮ, зураг төсөвгүйгээр аймаг, сумын ИТХ-аар батлагдсан, аймаг, сумын дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулаагүй зэрэг 1518.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүллээ. Холбогдох байгууллагуудад 41 албан шаардлага 16 заалт бүхий зөвлөмжийг тайлангийн хамт хүргүүллээ.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 114, аудитын өртөг 7.3 сая төгрөг, бүртгэсэн үр өгөөж 29.6 сая төгрөг

Б.Аймгийн Иргэдийн хурлын захиалгаар гүйцэтгэсэн аудит:

1. "Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагаа"-д аудит хийж, аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн "Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайланд хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна" гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.



Хатдын өргөө

"Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, аудитын дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн зохион байгуулсан эсэх, ашиглалтын өмнөх захиргаа батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулсан эсэх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт зүй зохистой эсэхэд аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэв.

Аудитаар "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь Барилгын тухай хуулийн 48.3 дахь хэсэгт "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно" заасныг зөрчсөн байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг эзэмшигч байгууллагад нь шилжүүлж, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг зохион байгуулаагүй зэрэг 445.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 8 заалт бүхий зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлсэн. Аудитын тайланг аймгийн

ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, аудитын дүгнэлтийг үндэслэн ашиглалтын өмнөх захиргааг татан буулгах, хуулийн этгээдийн хариуцлагын өөр хэлбэрт шилжүүлэх талаар саналаа Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг холбогдох байгууллагад үүрэг болголоо.

Аудитад зарцуулсан хүн/өдөр 68, аудитын өртөг 4.0 сая төгрөг, бүртгэсэн үр өгөөж 445.0 сая төгрөг

2.4 ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлж ажиллалаа. Аймгийн 2019 оны төсвийн орлогыг 933.0 сая төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1100.0 сая төгрөг нийт 2033.0 сая төгрөгөөр орлого нэмэгдүүлэх санал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдээс 4 төсөл арга хэмжээний нийт 591.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийн үр өгөөжийг анхаарч үзэх, мөн цаашид анхаарах асуудлаар 7 заалт бүхий зөвлөмж боловсруулан санал орууллаа. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаар бүрэн дэмжигдэж, орлогыг 2033.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын зардлыг хуульд нийцүүлэн үр ашигтай зардалд зарцуулахаар шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-аас саналыг хүлээн авч төсөвт тусгасан тухай 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн ... тоот албан бичгийг ирүүлсэн болно.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлж, ажлын уялдааг сайжруулах, мэдээллийг үнэн зөв, ил тод өгч байх зорилгоор аудитын тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд танилцуулах ажлыг тогтмолжууллаа. Үүнд:

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
- Газар болон орон нутгийн өмч хөрөнгийн дуудлага худалдааны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит

- Хэнтий аймгийн газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани болон бусад аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтын төлбөрийн ногдуулалт, төсөвт төвлөрүүлсэн байдалд хийсэн гүйцэтгэлийн аудит
- Хэнтий аймгийн Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудит
- “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудит
- “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаа”-д хийсэн гүйцэтгэлийн аудит
- Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Малжуулах төсөл” хөтөлбөрийн 2014-2017 оны үйл ажиллагаанд хийсэн аудит.

ГУРАВ. СУРГАЛТЫН ТАЛААР

Үндэсний аудитын газраас жил бүр зохион байгуулдаг удирдах ажилтны зөвлөгөөнд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор амжилттай оролцов. Тус зөвлөгөөн 2018 оны 3 дугаар сарын 19-нөөс 20-ны өдрүүдэд Төрийн ордонд болж, зөвлөгөөний үеэр 2017 онд хийсэн ажлын үр дүнг хэлэлцэн, 2018 оны бодлого, зорилт дэвшүүлэв. Өнгөрсөн жил төрийн аудитын байгууллагын хэмжээнд “Сахилга хариуцлагыг сайжруулах” жил болгон ажилласан ба 2018 онд “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” зорилт тавьж ажиллахаар болсон.





ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ, СЕМИНАР, ЗӨВЛӨГӨӨН



Энэ зорилтын хүрээнд манай байгууллага ажлын үзүүлэлтээрээ 13-р байранд байгаад дүгнэлт хийж энэ онд нэлээд шахуу төлөвлөлтийн дагуу ажлаа зохион байгуулж ажилласан.

✓ Ажилтнуудын мэргэжлийн тасралтгүй сургалтын хэрэгцээг тодорхойлж, ажлын байран дахь МТС-ын төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. МТС-ын төлөвлөгөөний дагуу дотоод сургалтаар ерөнхий мэдлэг болон аудитын талаар нийт 8 ургалт явуулж, 2018 онд шинээр батлагдан гарсан журам, зааврын талаар

тухай бүр бүх ажиллагсдыг хамруулж, ажлын байрны чиг үүрэгтэй холбогдолтой мэдлэгээ дээшлүүлэх талаар анхаарч ажиллалаа.



Дотоод сургалт

✓ Цахим тестийн сангаас тест бөглөх ажлын хүрээнд бүх аудитор, шинжээч нараас сард 1 удаа www.audit.mn бев сайтнаас тестээр сорил шалгалт авч үр дүнг үнэлж ажиллалаа. Үүний үр дүнд Дорнод аймагт зохион багуулагдсан 5, 10, 15 дахь жилдээ ажиллаж буй аудиторуудын мэргэжлийн түвшин тогтоох шалгалтанд орсон 3 аудитоор 90-ээс дээш буюу “онцгой сайн” үнэлгээ авч өндөр үр дүн үзүүлсэн.

✓ Бусад сургалтын хүрээнд аймаг дахь Цагдаагийн газрын хууль эрх зүйн сургалт хариуцсан мэргэжилтнээр “Зөрчлийн тухай хууль”-ийн талаар сургалт авч бүх ажиллагсдыг хамруулав.



“Зөрчлийн тухай хууль” сургалт

✓ Ганцаарчилсан сургалтын хүрээнд аудитын менежер Д.Оюунтуяа, ахлах аудитор Д.Эрдэнэбилэг нар АХБ-ны ТА-9158 МОН: “Төслийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” төслөөс зохион байгуулсан ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АУДИТ сэдэвт сургалтад 24 кредит цаг, ахлах аудитор Б.Наранцэцэг ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтад хамрагдаж 18 кредит цаг, аудитор Ц.Хатанболд ЭМНДЕГ-аас зохион байгуулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж 16 кредит цагийг тус тус хангаж сертификат гардан авсан байна. Мөн дотоод ажил хариуцсан ажилтан Ч.Алтанзаяа Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн 28 өдрийн сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэн мэргэжлийн үнэмлэхтэй боллоо. ҮАГ-ын ажилтнуудыг чадавхижуулах Дэлхийн банкны зөвлөхүүдийн 1 өдрийн сургалтад ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, Ц.Хатанболд нар оролцов.

✓ Бүсчилсэн болон төвлөрсөн сургалтын хүрээнд ТАБ-ын 2018-2020 онд хэрэгжүүлэх сургалт, хөгжлийн стандартыг хэрэгжүүлэхээр 2018 онд төлөвлөсөн сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу аудитын менежер Д.Оюунтуяа “Аудитыг хянан удирдах арга зүй” сэдэвт аудитын менежерүүдийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж 20 цагийн хичээлийн агуулгыг эзэмшиж сертификат авсан.

✓ Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон “Тод санхүү” удирдлагын академитай хамтран “Нярав-Эд хариуцагчийн мэргэжил олгох, мэдлэгийг дээшлүүлэх” сургалтыг хамтран зохион байгууллаа. Сургалтад аймаг сумдын төсвийн байгууллагын 80 гаруй эд хариуцагч нар хамрагдав.



Нярав, эд хариуцагчийн сургалт

Тус сургалтаар эд хариуцагч нарт Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, баримтлаж буй бодлого, чиглэл, санхүүгийн тайлангийн аудитаар эд хариуцагч нартай холбоотой ямар алдаа зөрчил илэрч байгаа, цаашид хэрхэн анхаарах талаар мэдээлэл хийсэн. Мөн энэ үеэр бие биетэйгээ танилцах, нэг нэгнээсээ туршлага судлах зорилгоор гар бөмбөгийн тэмцээн болон оройн зоог барих үйл

ажиллагааг зохион байгуулсан. Сургалтын дараа бүх эд хариуцагч нараас шалгалт авч сертификат гардуулан, хамгийн өндөр оноо авсан 3 эд хариуцагчийг “Тод санхүү” удирдлагын академиас “Идэр” дээд сургуульд нягтлан бодох мэргэжлээр сурах эрх олгож, эхний нэг жилийн сургалтын төлбөрийг хөнгөлөх эрхийн бичгээр шагнаж урамшуулав.

✓ Төрийн аудитын байгууллагын “2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Үндэсний Аудитын Газрын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд албан хаагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх Зүүн бүсийн сургалт 2018 оны 10 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Дорнод аймагт боллоо. Уг сургалтад Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг дахь Төрийн Аудитын газрын нийт албан хаагчид оролцож байгаа бөгөөд сургалтыг УАГ-ын Стратеги удирдлагын газрын дарга Д.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг зохион байгууллаа.



Төрийн аудитын байгууллагын зүүн бүсийн сургалт

Тус сургалтаар Санхүүгийн тайлангийн аудитын шинэчилсэн журам, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүй, төрийн алба, төрийн болон албаны нууцын тухай, архив албан хэрэг хөтлөлт, төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцооны стратегийн талаарх сэдвүүдээр 2 өдрийн хичээлийг зааж, амьдрал дээр тохиолддог бодит жишээн дээр ажиллаж санал бодлоо хуваалцаж нэг нэгнээсээ санаа оноо авсан сайхан сургалт боллоо. Мөн Төрийн аудитын байгууллагад 5, 10 дахь жилдээ ажиллаж буй 15 аудитор мэргэшлийн түвшин тогтоох шалгалтад амжилттай хамрагдлаа.

✓ ТАБ-ын гадаад сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар Кубейт улсын Аудитын хороонд санхүү, гүйцэтгэл, мэдээлэл технологийн аудитын чиглэлээр 6 өдрийн сургалтад хамрагдсан.





Кувейт улсын Аудитын хороо


ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР

4.1 Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, нууцын чиглэлээр/эбат/

Тайлант хугацаанд тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 23 тушаал, боловсон хүчинтэй холбоотой 14 тушаал нийт 37 тушаал гарч тушаалын биелэлт 100 хувьтай байна. Оны эхнээс явсан бичиг 155 гарснаас хариутай албан бичиг 48-ийг төлөвлөж үүнээс хугацаандаа ирсэн 29, ирүүлэгүй 4, хугацаа болоогүй 15 албан бичиг байна.



Ирсэн бичиг цаасаар 258, цахимаар 145 нийт 403 албан бичиг ирснээс хариутай бичиг 64 байна. Үүнээс 60 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж 4 албан бичгийг хугацаа хоцроосон байна. Аймаг дахь Төрийн аудитын байгууллага нь удирдлагын зөвлөлийн хурал – 12, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал – 2, хамт олны хурал – 12, бусад уулзалттай холбоотой хурал – 6 хийсэн байна.



МУЕА-ын тушаалыг цахим хэлбэрээр болон цаасан баримт үүсгэн хадгалаж байна. Мөн УАГ-аас дотоод сүлжээгээр танилцуулагдсан мэдээ, мэдээлэл, сургалт, цахим хуралд тогтмол оролцон үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хангаж ажиллалаа.

Аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 онд хөтлөгдөх “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг боловсруулан 2 сарын 1-нд батлуулав. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтийн дагуу ажилчдаас 261 баримт материалыг архивт шилжүүлэн авхаар баталсан бөгөөд 166 хадгаламжийн нэгжийг архивт шилжүүлэн авсан байна. “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу архиваас баримтыг түр гаргах болон ашиглуулахдаа ажилчдаас хүсэлт бичүүлэн, баримт түр ашиглуулахаар олгох акт үйлдэн ажиллаа. Аймгийн архивын тасагт “Баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээ”-г гаргаж хүргүүлэв. Архив, албан хэрэг хариуцсан ажилтанг “Төрийн албан хэрэг хөтлөлт” сэдвээр 66 цаг, архивын онол арга зүй сэдвээр 76 цаг, албан хэрэг, хөтлөлт, архивын мэдээллийн технологи сэдвээр 22 цаг зэрэг нийт 164 цагийн сургалтад хамрууллаа.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт нийт 1327 ширхэг хадгаламжийн нэгж хадгалагдаж байгаагаас төрийн архивт шилжүүлэх 107 ширхэг хадгаламжийн нэгж байна. 2009-2017 он хүртэл нийт 927 ширхэг хадгаламжийн нэгж байгаа бөгөөд үүнээс 2017 онд 134 ширхэг хадгаламжийн нэгжийг “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ийн дагуу архивт шилжүүлэн авсан.

Тухайн онд 2 удаа архивын баримт бичиг нягтлан шалгах комисс гарган ажилласан. Баримт бичиг нягтлан шалгах комисс нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүртгэгдсэн хадгаламжийн нэгж тус бүрээр төрийн архивт шилжүүлэх байнга хадгалагдах баримтыг сонгох, баримтын хадгалах хугацаа, баримтын бүрдэл зэргийг тодорхойлохоор нягтлан шалгасан болно.



Шинээр тавиур хийж баримтыг цэгцлэв

Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоол “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дагуу байгууллагын цаасан суурьтай архивын баримтыг цахимжуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Манай байгууллагын хувьд архивын тусгай өрөө, тасалгаа байхгүй байсныг шийдвэрлэж, өрөө, тасалгааг цэвэрлэж тохижуулан, архивыг цэгцлэх ажлыг эхлүүлээд байна. Тайлант хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаа, ажиллагсдын мэргэжлийн ур чадвар

ёс зүйтэй холбоотой болон аудит хийлгэх тухай хүлээн авсан мэдээлэл, хүсэлт, өргөдөл байхгүй болно.

Ажилтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар болон цаасаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулж мөн аудит хийх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан ажиллаж байна.

4.2 Хүний нөөцийн чиглэлээр хийгдсэн ажлууд

Тайлант онд нийт ажилтнуудын дэлгэрэнгүй судалгааг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар шинэчлэн гаргаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн баяжилтыг хийв.

Төрийн албаны зөвлөлийн цахим мэдээллийн санд ажилтнуудын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг оруулж, холбогдох ажилтнаар баталгаажуулсан.

Тэргүүлэх аудитор аудитын менежертэй, аудитын менежер ажилтнуудтай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулсан ба хагас бүтэн жилийн үр дүнгийн гэрээний биелэлт болон Төрийн аудитын байгууллагын ажилтны тухайн жилд хийсэн ажлын тайланг гаргуулан авлаа.

Тайлант онд төрийн жинхэнэ албан хаагчийн 2018 оны үр дүнгийн гэрээг дүгнэхэд 1 ажилтан “А” үнэлгээтэй, 8 ажилтан “В” үнэлгээтэй үнэлэгдсэн ба нийт ажиллагсдын дундаж үнэлгээ өмнөх онд 86,61 байсан бол энэ онд 87,9% болж өссөн байна.



Аудитын олон улсын стандартыг нэвтрүүлэх, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн МУЕА-ын 2018 оны 03 сарын 19-ны өдрийн А/47 дугаар тушаалаар “Төрийн хяналтын тэргүүний ажилтан цол” тэмдгээр аудитор Х.Еркегүлийг мөн МУЕА-ын 2018 оны 07 сарын 05-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдгээр аудитор Ц.Хатанболд, Ц.Нарангэрэл нар шагнагдсан.



Санхүүгийн тайлангийн аудит хийх хугацаанд түр гэрээт ажилтан сонгон шалгаруулж Б.Цэнгэл, Х.Ганцэцэг нарыг 3 сарын хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулсан.

Сар бүрийн 3 дахь долоо хоногт хүний нөөцийн хөдөлгөөний статистик мэдээг тогтмол гаргаж, нийт 12 мэдээг хугацаанд нь хүргүүлэв.

МУЕА-ын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Б/30 тоот тушаалаар аудитын менежерээр Д.Оюунтуяаг, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 тоот тушаалаар мэдээлэл технологийн ажилтнаар Ч.Алтанзаяа нар тус тус томилогдон ажиллаж байна.

Сар шинийн баяр болон ахмадын баярыг тохиолдуулан ахмад настан Б.Очирхуягт хүндэтгэл үзүүлсэн.

4.3 Мэдээлэл технологи, мэдээ, мэдээллийн чиглэлээр

Байгууллагын хэмжээнд мэдээлэл технологийн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг гаргаж тэргүүлэх аудиторроор батлуулж, байгууллагын компьютерүүдийн программ хангамжийг дээшлүүлэх үүднээс нийт ашиглаж буй 12 компьютерт Kaspersky антивирусын эсрэг программыг шинээр суулгаж лицензийг шинэчиллээ. Мөн улирал бүр хамгаалалтын нууц үгийг шинэчилж албажуулав. Үндэсний аудитын газраас хийсэн дотоод видео хурлын бэлтгэл ажлыг хангаж, ажилтнуудыг бүрэн хамруулж ажилласан.



Байгууллагын сүлжээний свитч, рүүтэр гэмтэлтэй байсныг тогтоож 4 дүгээр сард ҮАГ-т уламжилснаар асуудал шийдэгдэж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа. Байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа компьютер, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал мөн дотоод сүлжээний хэвийн ажиллагааг ханган, шинээр сүлжээ татах болон тоног төхөөрөмж суурилуулах, сүлжээний гэмтлийг тухай бүрд нь засварлаж байна.

Төрийн аудитын байгууллагын цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбар, орон нутгийн сонингоор дамжуулан 2018 онд хийсэн гүйцэтгэл, нийцлийн болон санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгийн талаар тухай бүр товч мэдээлэх ажлыг зохион байгуулж хэвшээд байна. Тайлант хугацаанд ҮАГ-ын цахим хуудсанд аудитын талаар 15, бусад 12 мэдээллийг байршуулсан байна.



“Хэнтий мэдээ” сонин

Дотоод мэдээллийн сан

“Хэнтийн мэдээ” сонинд аудитын байгууллагын үйл ажиллагааны болон аудитын тайлангийн талаар 10 мэдээлэл, “Хэнтий ньос” сэтгүүлд 2 мэдээлэл нийтлүүлж, “Хэнтий телевиз”-ээр “Иргэний танхим”-ын үйл ажиллагааны талаар ярилцлага, мэдээг өгч сурталчлав.

Энэ онд аудитын тайланг цахимжуулах, дотоод мэдээллийн санд байршуулах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд **Хэнтий аймгийн 155 төсөвт байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн СТА-ын тайлангууд, “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл”, “Аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”, мөн Санхүүгийн аудитын– 2, Гүйцэтгэлийн аудитын – 6, Нийцлийн аудитын – 3** аудитын тайланг www.audit.mn сайтад бүрэн байршуулсан.

Бусад байгууллагад 5 удаа төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, баримталж буй бодлого, чиглэл, санхүүгийн аудитын дүн болон илэрсэн алдаа зөрчил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ.

4.4 Хамтын ажиллагаа

Аймгийн ЗДТГ-тай хамтарч “Сахилга хариуцлагыг сайжруулах нь” удирдах ажилтны 2-р зөвлөгөөнийг зохион байгуулж, 204 төсвийн шууд захирагч нарыг хамруулан 2 өдрийн сургалт семинарыг зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, баримталж буй бодлого, чиглэл цаашдын чиг хандлага, төсөвт байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн, дүгнэлт, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ. **Удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөн**



✓ Сумдын эрүүл мэнд болон боловсролын салбарын төсөв захирагч нар, аймгийн нийгмийн хөгжлийн хэлтэс, эрүүл мэндийн газар, боловсрол соёл урлагийн газрын удирдах ажилтнуудтай уулзалт ярилцлагыг тус бүр салбараар нь зохион байгуулан тухайн салбарт гарч буй алдаа зөрчил, анхаарах асуудал, хууль эрх зүйн талаар тодорхой зөвлөмж өгч, мэдээлэл хийлээ. Салбаруудын төсөв захирагч нар төсөв санхүүгийн талаар асуулт асууж, тулгамдаж буй асуудлуудын талаар нээлттэй ярилцлаа. Мөн энэ үеэр төсөв захирагч нарт аудитын тайланг гардуулан өглөө.



Боловсролын салбар



Эрүүл мэндийн салбар

✓ Хэрлэн сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **"ТӨРИЙН АУДИТ -2018"** нөхөрсөг спортын тэмцээнийг 5 дугаар сард амжилттай зохион байгууллаа.



"Төрийн аудит 2018" спорт арга хэмжээ

Уг тэмцээнд 50 төсөвт байгууллагын 100 гаруй удирдах ажилтнууд хамрагдаж, 8 баг болгон гар бөмбөг, бадминтон, нийтийн бүжиг гэсэн 3 төрлөөр явуулж, тус бүр 3-н байр эзлүүлэн, багийн дүнгээр тэргүүлсэн багт "Шилжин явах цом" гардуулан өгөв. Тэмцээний төрөл тус бүрийн эхний 3-н байранд орсон

тамирчдад өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал зэрэг нийт 1346.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Гар бөмбөгийн тэмцээнд: Г.Нямхатан ахлагчтай “Хүчит луунууд” баг 1-р байр 200.0 мянган төгрөг, Б.Баттүвшин ахлагчтай “Аврагч” баг 2-р байр 150.0 мянган төгрөг, Д.Баярхүү ахлагчтай “Сүлдэн шонхор” баг 3-р байр 100.0 мянган төгрөг



Г.Нямхатан ахлагчтай “Хүчит луунууд” баг

Бадминтоны тэмцээнд: Б.Амгаланбаатар ахлагчтай “Эрчит хүлгүүд” баг 1-р байр 80.0 мянган төгрөг, Г.Нямхатан ахлагчтай “Хүчит луунууд” баг 2-р байр 60.0 мянган төгрөг, Д.Баярхүү “Сүлдэн шонхор” ахлагчтай баг 3-р байр 40.0 мянган төгрөг

Бүжгийн тэмцээнд: Б.Амгаланбаатар ахлагчтай “Эрчит хүлгүүд” баг 1-р байр 50.0 мянган төгрөг, И.Пүрэвдорж ахлагчтай “Хар сүлд” баг 2-р байр 30.0 мянган төгрөг, Д.Баярхүү ахлагчтай “Сүлдэн шонхор” баг 3-р байр 20.0 мянган төгрөг. Нийт багийн онооны дүнгээр Б.Амгаланбаатар ахлагчтай “Эрчит хүлгүүд” баг тэргүүлж Шилжин явах цом 100.0 мянган төгрөгөөр шагнууллаа.



*Б.Амгаланбаатар ахлагчтай
“Эрчит хүлгүүд” баг*



*Д.Баярхүү ахлагчтай
“Сүлдэн шонхор” баг*

✓ ММНБИ-ийн Зүүн бүсийн салбаруудын гишүүдийн уулзалт-өдөрлөг 10-р сарын 13,14-ний өдрүүдэд Хэнтий аймагт болж, аймаг дахь Төрийн аудитын газрын мэргэшсэн нягтлан бодогч нар хамрагдсан байна. Өдөрлөгт Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Налайх, Багануур салбарын 100 орчим гишүүд оролцлоо.



Уулзалт өдөрлөгөөр ММНБИ-ийн ерөнхийлөгч Б.Түвшин, гүйцэтгэх захирал Л.Энх-Амгалан, Удирдах зөвлөлийн гишүүн Г.Энхбилэг, Л.Батцэнгэл нар оролцож “ММНБИ-ийн удирдах зөвлөлийн 2018 оны ажлын явц”, “Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ирээдүйн чиг хандлага, өөрчлөлт, шинэ ойлголтууд”, “ММНБИ-ийн үйл ажиллагаа, цаашдын зорилт”, “МНБ-ийн ёс зүй” сэдвүүдээр мэдээлэл хийж, гишүүдтэй чөлөөт уулзалт хийлээ. Энэ үеэр ММНБИ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, манлайлагч зарим гишүүдийг ММНБИ-ийн шагналаар шагналаа.



Салбаруудын дунд спортын нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, Хэнтий салбарын баг түрүүлж Зүүн бүсийн салбаруудын шилжин явах цом хүртлээ.

✓ Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар төсвийн байгууллагын дарга эрхлэгч нарт 2018 онд хийгдсэн аудит, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж байгаа аудитын явц болон төсөв

санхүүгийн анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ. Нийт 40 төсвийн шууд захирагч нар оролцов.



Төсвийн шууд захирагч нартай уулзав

✓ Монгол улсын Засгын газрын 2018 оны 07 сарын 06-ны өдрийн “Хүүхдийг эрсдэлд өртөхөөс сэргийлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг хангуулах ажлын хүрээнд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын байгууллага 11 сарын 12-ны өдрөөс 19-ныг хүртэл байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа зохион байгууллаа. Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн суралцах нөхцөлийг бүрдүүлэх, олон хүүхэдтэй айлд дэмжлэг үзүүлэх чиглэлээр нэг албан хаагчийн бага ангийн 2 хүүхдэд цүнх, дэвтэр, бал зэрэг хичээлийн хэрэгсэл бэлэглэлээ. Мөн сургуулийн насны хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор үзвэр, үйлчилгээ үзүүлэв.



“Хүүхдэд ээлтэй аян-45 хоног”

Төрийн аудитын байгууллагын Аудитын менежер Д. Оюунтуяа нийт албан хаагчдад “Хүүхдэд ээлтэй орчин” сэдэвтэй хүүхдийн хүрээлэн буй орчны аюулгүй байдал, тэдгээрийг хэрхэн эрсдэлээс хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулав. Мөн “Хүүхэд залуучуудын хөгжлийн төв”-ийн нээлтэд Аудитын менежер Д.Оюунтуяа, дотоод ажил, мэдээлэл технологийн мэргэжилтэн Ч.Алтанзаяа нар байгууллагаа төлөөлөн оролцож тус төвийн шинэ номын санд ном хандивлалаа.

✓ Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах ажлын хүрээнд “Эрүүл-Монгол хөтөлбөр”, болон “Урьдчилан сэргийлэх багцын үзлэг”-т бүх ажилтнуудыг хамруулан оношлогоо шинжилгээ хийлгэлээ.



Үзлэгт хамрагдав

4.5 Ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр

Аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 оны 9 сард “Цэсэнгоо” ХХК -тай “Засварын ажлын гэрээ” байгуулан байгууллагын 4 өрөөнд засвар үйлчилгээ хийлгэлээ.



Засварын явц



Менежерийн өрөө/засварын явц/



Дараа нь

Менежер Д.Оюунтуяагийн өрөөнд эко хавтангаар бүрэн доторлогоо, уналттай тааз, хаалга шинээр суулгах, цонхтой талын ханын хэсгийн доторлогоо, цонхны амалгаа, халаалтын паарны өмнөх хаалтыг суулгах, гэрэлтүүлэг, залгуур, унтраалга шинээр суулгах, хаалганы амалгаа эко хавтангаар хийх, хөшиг тогтоох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн аудитын алба болон, нийцэл гүйцэтгэлийн албаны тус бүр 27,5м квадрат талбай бүхий өрөөнүүдэд уналттай тааз шинээр хийх, ханануудад хагас доторлогоог эко хавтангаар хийх, паркетан шал шахах, хаалгануудыг шинээр сольж амалгааг эко хавтангаар хийх, гэрэлтүүлэг, залгуур, унтраалгыг шинээр угсарч тавих, ханын шүүгээг шинээр нэмж хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



Гүйцэтгэл, нийцлийн багийн өрөө



Санхүүгийн багийн өрөө

Түүнчлэн тус газрын дотоод ажил, мэдээлэл технологи хариуцсан ажилтны өрөөнд паркетан шалыг шинээр тавих, явган хана хийх, хаалгыг шинээр суулгах, хаалганы амалгааг эко хавтангаар хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.



Дотоод ажил хариуцсан ажилтны өрөө

Ажилтнуудын ажиллах чадамжийг дээшлүүлэх, тоног төхөөрөмжийн чанарыг сайжруулах зорилгоор 6 ширхэг зөөврийн компьютер, дагалдах хэрэгсэл, хөргөгч сэнсийн хамт хүлээлгэн өглөө.



Байгууллагын дотоод тохижилтыг сайжруулах, ажилтнуудын өрөө тасалгааг цэцэгжүүлэх “**Эко тасалгаа**” ажлын хүрээнд ажилтан тус бүр 15 ширхэг цэцэг тарьж ургуулан эко орчинг бүрдүүллээ.



Өрөө, тасалгаануудыг цэцэгжүүлэв

4.6 Бусад ажлын талаар

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/64 тоот тушаалаар “Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал” батлагдсан. Энэхүү тушаалыг үндэслэн СУГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2017 оны санхүүгийн тайланд гэрээгээр хийсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг хялбаршуулсан загвар маягтаар “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК, “Өндөрхаан Итгэл Аудит” ХХК-иудын гүйцэтгэсэн аудитын ажлыг үнэлсэн.

Чанарын баталгаажуулалтын албаны шалгалтаар өгсөн 26 зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, хийсэн ажлын тайланг нотлох баримтын хамт ЧБАлбанд хүргүүлэн ажилласан.

МУЕА-ын “Ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгах, ажлын чанар үр дүнг дээшлүүлэх” 2018 оны 01 тоот албан даалгаврын дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

МУ-ын ЗГ-ын сахилга хариуцлагыг дээшлүүлэх тогтоолын хэрэгжилтэд хийгдсэн шалгалтаар манай байгууллага 98.5 оноо авч, амжилттай дүн үзүүлсэн.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудад аудит хийх” ГАГ-2018-02-ГА-ХЭ. Тус аудитын хүрээнд нэмэлт судалгааны ажлыг 2018 оны 8 дугаар сарын 29-нөөс 9 дүгээр сарын 08 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн, ШУТИС-ийн 4 багш нараас бүрдсэн хөндлөнгийн шинжээчдийн ажлын хэсэг хөндлөнгийн үнэлгээ хийхээр 2018 оны 10 дугаар сарын эхний долоо хоногт ирж Хэрлэн, Биндэр суманд ажиллав. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Өндөрхаан хотод барьж эхэлсэн 8353.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хан Хэнтий” чуулгын барилга, Биндэр суманд 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн шинэчлэл” зэрэг төсөл арга хэмжээнүүдийн барилга угсралтын ажилд хөндлөнгийн аудит үнэлгээ хийхээр Монгол улсын Тус ажлын хэсгийг аймаг дахь Төрийн аудитын газраас холбогдох ажилтан болон автомашинаар хангаж ажиллалаа.

“Монгол улсын алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт” ГАГ-2018-05-ГА. Тус аудитын хүрээнд Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт 2015-2018 онд үйл ажиллагаа явуулж байгаа давхардсан тоогоор 13 ААН-ийн үйлдвэрлэлд ашиглаж буй 6468 га талбай, байгаль хамгаалах үйл ажиллагааны 35,2 сая төгрөгийн зардалд 2018 оны 9 дүгээр сарын 26-наас 10 дугаар сарын 30 хүртэлх хугацаанд аудит хийж холбогдох судалгааг Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүллээ. Мөн энэ хугацаанд Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор Б.Болормаа, аудитор Д.Даваа-Очир нар манай аймагт ажиллаж “Айвуун тэс” ХХК, “Дацан трейд” ХХК-ний алтны ордын олборлолт, нөхөн сэргээлтийн байдлыг газар дээр очиж шалгалаа. Тус аймгийн нутаг дэвсгэрт алт олборлож буй ААН-ийн үйл ажиллагааны талаар аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан, аймгийн Засаг дарга Н.Ганбямба, аймаг дахь ТАГ-ын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар болон аймгийн БОАЖГ, аймгийн МХГ-ын зэрэг холбогдох бусад газар хэлтсийн ажилтнуудтай уулзаж тус хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар төрийн байгууллагуудын оролцоог үнэллээ.



Хэнтий аймгийн Засаг даргын өрөөнд уулзалт хийв

"Монгол улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдал" ГА УАГ-ГАГ/2017/12-ГА-01. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдэж буй "Монгол улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д хийх аудитын хүрээнд Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй 37 аж ахуйн нэгжийн 4.1 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт, үйл ажиллагаа явагдаж буй эсэх, үр дүнд хүрсэн эсэхэд аудит хийлээ. Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 2-оос 11 дүгээр сарын 20 хүртэлх хугацаанд аудитыг хийж гүйцэтгэн аудит хийсэн танилцуулгыг холбогдох судалгааны хамт үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлээ. Аудитын дүнд 5 төсөл арга хэмжээ нь салбарын яамнаас шууд олгогдсон тул мэдээлэл байхгүй, 13 аж ахуйн нэгж, иргэн 504.1 сая төгрөгийн зээлийг бүрэн барагдуулж 15 зээлдэгч 696.1 сая төгрөгийг төлж, 842.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Төсөлд хамрагдсан 23 аж ахуйн нэгж байнгын болон улирлын чанартай 70 ажлын байрыг бий болгосон бол үлдсэн 14 төсөл арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй, ажлын байр бий болгоогүй байна. Нийт 4 ААН, иргэн 97,1 сая төгрөгийн зээлийг төлөөгүй хугацаа хэтэрсэн байна.

ТАБ-аас 2019 онд хийх "Мэргэжлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн", "Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитад шаардагдах зардлын тооцоог хийж хүргүүлэв.

ТАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 онд санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулснаар 2018 онд 229.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийн хүрээнд өр авлага үүсгэхгүйгээр захиран зарцуулж байна.

Байгууллагын нэмэлт төсвийн дансанд 51.4 сая төгрөгийн аудитын үйлчилгээний төлбөрийг төвлөрүүлэн, Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс гэрээний үндсэн дээр 42 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийсэн "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК, "Өндөрхаан Итгэл Аудит" ХХК-иудад гэрээний дагуу 13.2 сая төгрөгийг шилжүүлэв. Мөн МУЕА-ын тушаалаар 25.0 сая төгрөгийн зарцуулах эрхийг шийдвэрлүүлж ажилчдын өрөөний засварт 7.0 сая төгрөг, тавилга эд хогшилд 8.1 сая төгрөг, компьютер худалдан авахад 9.8 сая төгрөгийг тус тус зарцуулж үлдэгдэл 13.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.


Аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд тооцон, саналаа УАГ-т хүргүүлсэн.

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтоосон хугацаанд аймгийн төрийн сангаар баталгаажуулан УАГ-ын санхүүгийн албанд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын тайланг хуульд заасан хугацаанд гарган цахимаар илгээж, цаасаар баталгаажуулан ажиллаж байна. "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын мэдээллийн самбарт бүрэн байршуулж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.



Д/д	Төсвийн байгууллагын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэсэн төсөв	Хэмжээтэй хэргэлт
1	Төсвийн байгууллагын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэсэн төсөв	Хэмжээтэй хэргэлт
2	ИЙД	223,544,100.00	99,638,200.00	6,585,075.00
3	НИЙТ ЗАРГАГА БИ ЦЭГЭЭР ЭЗЭЙГИЙН ДӨН	223,544,100.00	99,638,200.00	6,585,075.00
4	УРСГАЙ ЗАРГАЛ	219,744,100.00	99,738,200.00	6,585,075.00
5	БАРЛА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,499,200.00	74,141,200.00	1,072,496.00
6	Цалин, хөлс болон нэмэгдэл үрэмжлэл	10,859,900.00	8,560,900.00	0.00
7	Дамжигдамж, нийгэмийн даатгалд төлбөр шалтгаал	0.00	0.00	0.00
8	Байр ашиглалттай холбоотой тогтоол зардал	7,470,000.00	3,071,000.00	134,299.00
9	Хөдөлгөөн, бариа материалын зардал	0.00	0.00	0.00
10	Нормативт зардал	0.00	0.00	0.00
11	Эд хэргэлт, урсгал захиарын мөсөл	6,500,000.00	2,500,000.00	1,600,000.00
12	Товмшилт, зөмч зардал	19,315,000.00	11,006,700.00	7,281,370.00
13	Бусадвар үйлчилгээний ажил, үйлчилгээний хэлбэр, хураамж	1,100,000.00	458,500.00	38,950.00
14	Бариа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00
15	УРСГАЛ ШИТГЭЛЭГ	3,000,000.00	200,000.00	200,000.00
16	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	3,000,000.00	200,000.00	200,000.00
17				

Тайлант хугацаанд 2017 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгүүлж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.



Жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахтай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу байгууллагын хөрөнгийн тооллогыг хийж, өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, шинээр орлогод авсан үндсэн хөрөнгө болон ашиглах боломжгүй болсон, үлдэх өртөггүй хөрөнгийг данснаас хасах хөрөнгийн судалгааг гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

Манай байгууллагын хувьд 2018 онд төлөвлөсөн ажлаа төлөвлөгөөний дагуу амжилттай сайн гүйцэтгэсэн гэж үзэж байна. Энэ хугацаанд ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хамт олны хамтач, ажил хэрэгч байдлыг нэмэгдүүлэх, эвсэг уур амьсгалыг бий болгох, түүнчлэн байгууллагынхаа тохижилт, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажилласан. Энэ оны хувьд манай хамт олон өмнөө тавьсан зорилтоо хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж байна.

Санал:

1. Санхүүгийн тайланд аудит хийх шинэ журам батлагдсантай холбогдуулан холбогдох зааврыг явцын аудит эхлэхээс өмнө гаргаж, орон нутагт хүргүүлэх.
2. Энэ онд байгууллагынхаа техник хэрэгслийн түвшинг зохих байдлаар нэмэгдүүлсэн боловч ирэх онд 6 ажилтны компьютерийг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг анхаарах. */нарийвчилсан судалгааг хүргүүлсэн байгаа/*
3. Манай аймгийн хувьд урьд нь 12 орон тоотой ажиллаж байсан бөгөөд 2017 оны шинэ бүтцээр 1 орон тоо хасагдан ажиллаж байгаа тул 2019 онд санхүүгийн аудиторын нэг орон тоог шийдэж өгөх.
4. Ирэх оны төсвийн хуваарилалтыг ил тод, тэгш, аймгуудын онцлог */газар нутаг, засаг захиргааны нэгжийн тоо зэргийг харгалзан/-*т тохируулан хуваарилахыг хүсье.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

МЕНЕЖЕР

...../М.ЭРДЭНЭБААТАР/

...../Д.ОЮУНТУЯА/

